

ХЯТАДЫН ЭДИЙН ЗАСГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

ЛИ И НИН*

1. Бүтцийн зохицуулалт

Хятадын "12 дугаар 5 жилийн төлөвлөгөө" энэ жилээс (2011) хэрэгжиж эхэлж байна. "12 дугаар 5 жилийн төлөвлөгөө"-ний үндсэн чиг шугам бол эдийн засгийн хөгжлийн арга хэлбэрийг өөрчлөх. Эдийн засгийн хөгжлийн арга хэлбэрийг өөрчлөхөд бүтцийн зохицуулалт хийх нь хамгийн чухал. Яагаад бүтцийн өөрчлөлт тийм чухал вэ? Үүнд доорхи хариултыг өгч болно. Дотоодын нийт бүтээгдэхүүн /ДНБ/ чухал, гэвч ДНБ-ий бүтэц бүр чухал. Бид түүхэн талаас нь авч үзье. 1840 онд Хятад Английн хооронд хар тамхины дайн үүссэн. Тухайн үед Хятадын ДНБ-ний хэмжээ Англи улсынхаас хамаагүй илүү байв. Гэвч манай ДНБ-ий бүтэц бол хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн голлосон, амуу тариа, хөвөн, буурцаг, цайны навч гэх зэргээс бүрдэж байсан. Хятадын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнд голдуу гар аргаар боловсруулсан хөвөн даавуу, торго гэх мэтээс бүрдэнэ. Гэтэл тухайн үеийн Англи улсад ган төмрийн үйлдвэрлэл хөгжиж, аж үйлдвэржилт эхэлсэн байсан. Англи улс

Европын хэд хэдэн аж үйлдвэржиж буй орнууд руу техник, тоног төхөөрөмж импортолдог байжээ. Английн хөвөн даавууг гар аргаар биш машинаар хийдэг. Англи улс мөн төмөр зам байгуулж, галт тэрэг, хөдөлгүүрт усан онгоц зэрэг орчин үеийн тээврийн хэрэгсэлтэй болсон байсан. Харин Хятадын хувьд хуучны далбаат усан онгоц, морь тэрэг зэргийг л ашиглаж байсан юм.

Одоо тэгвэл Японтой харьцуулж үзье. Та бүхэн сонин хэвлэлээс 2010 онд Хятадын ДНБ Японоос давж гаран, дэлхийд 2 дугаарт жагсаж байсныг мэднэ. Гэвч Хятадын хүн ам Японоос 10 дахин их, тиймээс нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээгээрээ Японоос 10 дахин бага байна гэсэн үг юм. ДНБ-ий бүтцийн хувьд ч гэсэн Хятад Японыг давж гарахгүй. Японы бүтээгдэхүүний бүтцэд шинэ технологийн эзлэх хувь их. Хятадад шинэ технологийн бүтээгдэхүүн харьцангуй бага. Тэр хэрээрээ ДНБ дотор шинэ технологийн эзлэх хувь нь ч бага байдаг.

Би өнгөрсөн жил Японд суугаа Хятадын

* ЛИ И НИН - БНХАУ-ын нэрт эдийн засагч, профессор

Профессор Ли И Нин нь БНХАУ-ын 11 дэх удаагийн Бүх Хятадын Улс Төрийн Зөвлөлдөх Зөвлөлийн байнгын хорооны гишүүн, Бүх Хятадын Улс төрийн зөвлөлийн эдийн засгийн комиссын дэд эрхлэгч, БНХАУ дахь Олон улсын эдийн засгийн харилцааны төвийн гүйцэтгэх дэд эрхлэгч, Хятад улсын аж үйлдвэрийн хөрөнгө оруулалтын нийгэмлэгийн дэд дарга, Бээжин Их сургуулийн Нийгмийн ухааны сургуулийн хэлтсийн дарга, мөн их сургуулийн Гуанг Хуа удирдлагын ухааны дээд сургуулийн хүндэт ерөнхийлөгч. Эдийн засгийн онолын сэдвээр олон арван ном хэвлүүлж эрдэм шинжилгээний бусад салбарт ч бүтээл туурвисан нэртэй эрдэмтэн. "Ром-Византын эдийн засгийн түүх", "Хятадын эдийн засгийн өөрчлөлт ба хувьцаа", "Капитализмын үүсэл-эдийн засгийн түүхийн харьцуулсан судалгаа" зэрэг олон ном бүтээл гаргажээ. БНХАУ-ын Бондын тухай хуулийн эх төсөл боловсруулах багийн ахлагчаар ажилласан байна. 2011 онд нэрт эдийн засагч, профессор Ли И Нин Монгол Улсад айлчилж "Хятадын эдийн засгийн өнөөгийн байдал" сэдвээр лекц уншсан юм. Уг лекцийг бүрэн эхээр толилуулж байна.

элчин сайдын урилгаар Японд очиж судалгаа хийв. Япон улс дахь Хятадын ЭСЯ-ны зөвлөх надтай хамт Токио, Осака, Кобэ хотуудаар явсан. Зөвлөх надад маш чухал зүйл хэлсэн юм. 1920-30-аад оноос хойш Японы хот төлөвлөлт бараг өөрчлөгдөөгүй. Токио, Осакад бол Бээжин Шанхайтай адил энд тэндгүй өндөр барилга бариад байхыг олж харахгүй. Харин Япон айлд ороод үз, тэндээс маш том өөрчлөлт гарсан байхыг олж харж болно. Амьдарч байгаа байр нь бол урьдын л байр нь, гэтэл ариун цэврийн тоноглол, галын өрөөний хэрэгслэл, унтлагын өрөө гээд бүгд орчин үеийн өндөр технологийн бүтээгдэхүүн байна. Энэ л Японы онцлог. Японы ДНБ-ий бүтэц биднээс хамаагүй илүү орчин үетэйгээ хөл нийлүүлэн явж байна гэж тэр хэлсэн.

Одоо хүн хүчний нөөцийн бүтцийг авч үзье. 1840 онд хар тамхины дайны үед, Англи улс аж үйлдвэржээд 70, 80 жил болсон байсан. Маш олон бага сургуультай, дунд болон ахлах анги ч ихээр нээгдэж, зарим нэг их сургууль шинээр нээгдээд байсан үе. Жил бүр судлаач, инженер, эдийн засаг, санхүүгийн мэргэжилтнийг маш олноор бэлтгэн гаргаж байв. Техникийн мэргэжилтэн ч олноор нь бэлтгэн гаргаж байсан. Харин тэр үед Хятадын хүн ам Англиас хавьгүй илүү олон байсан боловч хүн хүчний нөөцийн бүтэц сул байв. Тариачдын ихэнхи нь бичиг үсэггүй. Эмэгтэйчүүд мөн адил бичиг үсэгт суралцаагүй байсан. Ном эрдэмтэй цөөн тооны хүмүүс нь юу уншиж судалдаг байсан бэ гэхээр "Дөрвөн ном таван судар" гэх мэт. Хааны ордонд шалгалт өгөх гэж байгаа хүмүүсээс хэд нь орчин үеийн шинжлэх ухаан, технологийг мэддэг, хэд нь эдийн засаг, санхүү, удирдлагын ухаан мэддэг байсан

бол? Эндээс хүн хүчний нөөцийн бүтэц хүн хүчний нөөцөөс хавьгүй илүү чухал болох нь харагдаж байна. Манай улс хүн хүчний нөөц ихтэй хэдий ч бүтцийн зохицуулалт хийх зайлшгүй шаардлагатай байна.

Манай улс Японтой харьцуулахад ДНБ-ий бүтцээс гадна хүн хүчний нөөцийн бүтцийн хувьд ч асар их зөрүүтэй байна. Япон бол мэргэшсэн техникч олонтой улс. Харин манайд бол маш цөөн байдаг. Японд жил бүрийн их дээд сургууль төгсөгчид, түүн дотроо шинжлэх ухаан технологийн мэргэжилтэн, эдийн засаг, санхүү, удирдлагын мэргэжилтнүүд Японы нийт хүн амтай харьцах харьцаа Хятадаас хавьгүй их. Энэ жишээ гэхэд л манай улс хүний нөөцийн бүтцийн зохицуулалт хийж орчин үеийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэх хэрэгцээ хичнээн чухал байгааг харуулж байна.

2. Инфляци

Онолын үүднээс инфляцийг 3 төрлөөр ангилж болно. Эхнийх нь эрэлтийн инфляци. Эрэлтийн инфляци гэдэг нь хөрөнгө оруулах хэрэгцээ ихсэж, зээл олголт нэмэгдсэнээр үүссэн инфляцийг хэлнэ. Энэ төрлийн инфляцийн өсөлт нь бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн материалын үнийн өсөлт бусад бүтээгдэхүүний үнийг хөөргөдөж байгаагаар илэрдэг. Хоёрдахь төрлийн инфляци бол үнийн нэмэгдлийн инфляци. Энэ нь бүтээгдэхүүний өртөг өссөний улмаас үүссэн инфляци юм. Гуравдахь төрлийн инфляци бол импортын инфляци буюу гадаад улсын инфляцийн өсөлт дотоодын эдийн засагт нөлөөлөх үзэгдлийг хэлнэ. Импортын инфляци нь хоёр замаар орж ирдэг. Нэг нь бараа эргэлтийг даган орж ирнэ. Жишээ нь: олон улсын хэмжээнд газрын тос, төмөр, хүнсний үнэ нэмэгдсэнээр

дотоодын зах зээлд нөлөөлөх. Хоёрдахь нь мөнгөний эргэлтийн явцад инфляци орж ирнэ. Учир нь мөнгө олон улс хооронд эргэлдэж байдаг бөгөөд үндсэн 2 чиглэлээр тардаг. Нэг нь хүүгийн зөрүүний чиглэл буюу хүү багатай орноос хүү өндөртэй орон руу мөнгө шилждэг. Нөгөө нь хүүг нэмснээр хөрөнгө мөнгөний урсгалыг өөртөө татдаг. Хөрөнгө оруулалтын ирээдүй бүрхэг, эдийн засгийн зогсонги байдалд орсон орон нутгаас хөрөнгө оруулалтын ирээдүй хайж өндөр хүүтэй орон руу мөнгө шилждэг. Мөнгөний урсгал нь бэлэн мөнгөний эргэлтийг нэмэгдүүлж, ингэснээр импортын инфляци үүсгэдэг.

Хятадын одоогийн инфляци нь аль ангилалд орох вэ? Хариулт нь гэвэл бүх шинжийг агуулсан, дээрхи 3 төрөл бүгд байна. Эхлээд эхний төрөл буюу эрэлтийн инфляцийг авч үзье. 2008 оны дэлхийн эдийн засгийн хямралын үеэр дотоодын ажилгүйдлийг бууруулах зорилгоор 4 тэрбум юаний хөрөнгө оруулалт хийсэн. Энэ нь эдийн засаг сэргэхэд сайн нөлөө үзүүлсэн хэдий ч нөгөө талаар хөрөнгө оруулах хэрэгцээг нэмэгдүүлсэн. Тиймээс одоо ч гэсэн хөрөнгө оруулалтын хэрэгцээ их байсаар байна. Импортын инфляци ч одоо байгаа. Жишээ нь олон улсад газрын тосны үнэ өссөн нь Хятадад нөлөөлсөн. Үүний гол шалтгаан нь Өрнөдийн улсуудын эдийн засгийн сэргэлт сайн биш хэвээр, зээлийн хүү бага байгаатай холбоотой. Өрнөдөд одоо ч гэсэн зээл олголтийг нэмэгдүүлэх арга хэмжээ авсаар байгаа, гэтэл Хятадад зээлийн хүү тэндээс өндөр байна. Тиймээс мөнгөний урсгал зээлийн хүү өндөр газар руу шилжиж, гадаадаас хөрөнгө мөнгө ихээр орж байна. Түүнээс гадна Европын эдийн засгийг сэргээх хөрөнгө оруулалтын хэтийн төлөв

тодорхойгүй байгаа тул хөрөнгө оруулалтын боломжийг Хятад, Энэтхэг, Бразили зэрэг улс гэж үзэж байгаатай холбоотой юм.

Хэдийгээр Хятадын инфляци нь холимог шинжтэй, эрэлтийн инфляци, импортын инфляци аль аль нь байгаа ч энэ удаагийн инфляцийн өсөлтийн үндсэн шалтгаан нь үнийн нэмэгдлийн инфляци юм. Үнийн нэмэгдлийн инфляци бол шинэ төрлийн инфляци юм. Америкт 20 дугаар зууны 70-аад оны эхээр энэ нэр томьёо анх гарч ирсэн. Өмнө нь гарч байсан инфляци бол ихэвчлэн эрэлтийн инфляци байсан бөгөөд эрэлтийн инфляцийн эсрэг авах арга хэмжээ маш хялбар. Санхүүжилтээ тандаж, зээл олголтыг багасгахад л асуудал шийдэгддэг байв. Энэ бол Кейнсийн онолын макро эдийн засгийн бодлого. Ерөнхий санаа нь эрэлтийг зохицуулж, инфляци гарвал шахаж гаргана. Хэрэв ажилгүйдэл ихэдвэл эрэлтийг цочрооно. Энэ бол Кейнсийн онол. Гэтэл 70-аад оны эхнээс Америкт стагфляци (үнийн төвшин болон ажилгүйдэл нэгэн зэрэг өсөх үзэгдэл) үүссэн. Стагфляци гэж юу вэ? Эдийн засгийн зогсонги байдал болон инфляци нэгэн зэрэг орших үзэгдэл. Энэхүү үзэгдлийг тухайн үед тайлбарлаж чадахгүй байсан. Кейнсийн онолоор бол инфляци байгаа тохиолдолд эдийн засаг зогсонги байдалд орохгүй, эдийн засаг зогсонги байдалтай байхад инфляци үүсэхгүй гэж үздэг. Гэтэл ийм үзэгдэл гарснаар Кейнсийн онол хүчингүй болсон. Эрэлтийг багасгая гэхээр эдийн засгийн зогсонги байдал даамжрах гээд, инфляцаа багасгах арга хэмжээ авсан ч инфляци өссөн хэвээр байсан.

Тэр үед Америкт онолын нэгэн шинэ чиглэл гарсан. Энэ бол "Нийлүүлэлтийн аргаар хямралаас гарах онол" юм. Энэхүү онолынхон

үзэхдээ асуудлыг эрэлтийг багасгаснаар шийдвэрлэх боломжгүй харин нийлүүлэлтийг нэмэгдүүлэх хэрэгтэй, учир нь үнэ өсөж байгаа шалтгаан нь нийлүүлэлт хүрэлцэхгүйд байгаа юм гэсэн. Харин нийлүүлэлтийг яаж нэмэгдүүлэх вэ? Хариулт нь татварыг багасгах хэрэгтэй гэсэн.

Хятадад одоо нүүрлэж буй үнийн нэмэгдлийн инфляци үүссэн шалтгаан нь юу вэ? Үүнд 4 төрлийн шалтгаан байна. Үүнд:

Нэгдүгээрт, түүхий эд, шатахууны хомсдлоос үүдэн өртөг өссөн. Хамгийн тод жишээ гэвэл газрын тос, нүүрсний үнэ жилээс жилд өсөж байна. Хаа сайгүй газрын тос, нүүрс, өнгөт металл хэрэглэх шаардлагатай. Тиймээс үнэ нь өсч нийлүүлэлт нь эрэлтээ хангаж чадахгүйд хүрсэн.

Хоёрдугаарт, Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнэ өссөн. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнэ өссөн шалтгаан бол их ярвигтай. 2010 онд цаг агаар муу, хавар нь Юннань, Гүйжоу, Гуанси мужуудад их ган болж, зун нь далайн эрэг дагуу нутгуудад далайн салхи, үер бууж, намар болоход хойд нутгийн ихэнх газруудад ган болсон. Энэ нь хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нийлүүлэлтийг бууруулсан. Гэтэл хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнэ амьжиргааны өртөгтэй шууд хамааралтай учраас бусад бүх бараа бүтээгдэхүүний өртөгт нөлөөлдөг. Түүнээс гадна, бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, худалдан авагч хоорондын зай улам бүр холдож, дунд шат дамжлага хэтэрхий их болж байгаа өнөө үед энэ төрлийн бараа бүтээгдэхүүний үнэ өсөх нь мэдээж юм. Тариачид тариан талбайдаа нэг жин ногоо зарах үнэ, томоохон дэлгүүрт худалдаалах үнэ хоёрын хооронд тэнгэр газар шиг зөрүү бий.

Дунд шат дамжлага хэтэрхий их байгаа нь бараа эргэлтийн асуудал юм. Мөн тээвэрлэх хөлс улам бүр өсөж байгаагаас барааны өртөг өссөн. Бас дээрээс нь өнөө үед ногоо тарих газар ч бараг байхгүй болж байгаатай холбоотой юм.

Бас нэгэн асуудал байгаа нь менежмент. Хөгжилтэй оронд буюу зах зээлийн эдийн засаг нь хөгжсөн улс орон 2 төрлийн нөөцтэй байдаг. Нэг нь засгийн газрын нөөц буюу улсын нөөц, нөгөө нь худалдааны нөөц. Зарим нэг улс орон том хэмжээний дэлгүүрүүдэд бүх бараандаа заавал хэд хоногийн нөөцтэй байх ёстой гэсэн шаардлага тавьдаг. Будаа хүрэлцэхгүй боллоо гэхэд томоохон дэлгүүрүүд нөөцтэй байна. Ингэснээр ард түмэн сэтгэл зүйн хувьд тайван байна. Ихэнхи тохиолдолд улсын нөөцийг хэрэглэж эхлэхэд хэтэрхий оройтсон байдаг. Эдгээр нөхцөл байдал нь хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнийн өсөлт болон үнийн нэмэгдлийн инфляцийн нэгэн шалтгаан болж байгаа юм.

Гуравдугаар шалтгаан бол, ажиллах хүчний үнийн өсөлт. Энэ нь юу вэ гэхээр товчоор хэлбэл цалин хөлс өсөх тухай юм. Гэтэл цалин нэмэхгүй бол болохгүй. Гуандунд зарим газар ажилчин олдохгүй байна. Би Гуанжоуд судалгаа хийх явцад, надтай уулзсан ажилчид "миний цалин 1000 юань, 10 жилийн өмнөхтэй адил, гэтэл энэ 10 жилд юмны үнэ хэр зэрэг өссөн билээ, цалин яагаад ийм бага хэвээрээ байгаа юм бэ?" гэж асууж байсан. Тэдний гомдоллох нь аргагүй. Түүнээс гадна, одооны хөдөөнөөс орж ирж байгаа ажилчид дээр үеийн хөдөөний ажилчдаас өөр. Одооны ажилчдыг шинэ үеийнхэн гэлцэж байна. Өмнө нь 80-аад онд хотод орж ирэгсдийг хуучин хөдөөний ажилчид гэдэг. Тухайн үед хотод авах цалин

хөдөөнөөс бага зэрэг өндөр байхад л болдог байсан. Хөдөөнөөс хотод ирж ажиллагсдын гал голомт, зүрх сэтгэл нь хөдөөнөө л байдаг байсан. Тэр үед ажилчид ажил хийж мөнгө олоод, эхнэр хүүхдээ тэжээнэ. Тодорхой хугацааны дараа буцаад хөдөө тосгондоо очдог байсан. Одооны шинэ үеийн хөдөөнөөс ирж байгаа ажилчид голдуу 80, 90-ээд онд төрсөн залуучууд. Тэдний зүрх сэтгэл хөдөө тосгондоо тогтохгүй. Тэд хөдөө нутгаа гал голомтоо гэж үздэггүй. Тэдгээр залуус хотод зөвхөн ажил хийж мөнгө олох гэж ирдэггүй. Тэд нэг л зүйлийг боддог, яагаад миний нийгмийн байр суурь хотынхоос дор байгаа юм бэ? яагаад миний хүүхэд хотын улсын сургуульд сурч болохгүй, заавал хөдөөний ажилчдын хүүхдүүд сурдаг сургуульд сурах ёстой юм бэ? Би эхнэртэйгээ хотод орж ирээд нэлээд удлаа, гэтэл одоо болтол яагаад хотын хүн болж чадахгүй байгаа юм бэ? гэсэн асуултад хариулт хайцгаана. Тэд бас хаана очиж ажиллахаа бодно. Зүүн урд нутгаас Гуандун, Фужянь, Жөжяньд очиж ажиллахад хэтэрхий хол, амьдралын өртөг өндөр. Өртөг гэдэгт зөвхөн ирэх очих зардлаас гадна өөр зардлууд ордог гэдгийг тэд ойлгосон. Хоёр газар тусдаа амьдрах, үр хүүхдээсээ хол амьдрахад зардал их гарна. Тиймээс тэд одоо ойрхон газраас ажил хайдаг болсон. Одоо бол жижиг хот тосгодод ч ажил олддог болсон. Яагаад заавал Гуандун явна гэж. Гуандунд одоо хамгийн олдоц муутай байгаа ажил мэргэжил бол техникийн мэргэшсэн ажилтан гэнэ. Гуандунд мэргэжлийн техникийн сургууль төгсөгчдийн 99% нь ажлын байртай болж байгаа, цалин ч өндөр байна.

Дөрөв дэхь шалтгаан бол газрын үнэ, үл хөдлөх хөрөнгийн үнэ өссөнтэй холбоотой.

Үүнийг эрэлтийн инфляци бий болгож байгаа. Газар болон үл хөдлөхийн үнэ өссөн нь эрэлтийн инфляцийн үр дагавар, нөгөө талаар үнийн нэмэгдлийн инфляци үүсэх шалтгааны нэг болж байгаа юм. Нэгэн жишээ авч үзье, үс засуулах үнэ өсчээ. Хаврын буюу цагаан сарын баяр болж байгаа учраас үнээ нэмсэн юм уу? гэтэл үгүй юм. Өнгөрсөн жилийн сүүлийн хагаст хэдийнэ үнээ нэмчихсэн байсан. Үсчний газрын эзний хэлж байгаагаар, тэрээр байр түрээслэн ажилладаг бөгөөд байрны түрээсийн үнэ 50 хувиар өссөн учраас үний зөрүүг та нарын үснээс л олж авна даа гэсэн. Энэ жишээ бол үнийн нэмэгдлийн инфляци юм.

Эдгээр шалтгааныг дурьдсанаар, нийлүүлэлтийг хумьж багасгах бодлого нь үнийн нэмэгдлийн инфляцийг барьж тогтооход ямар ч үр дүнгүйг харуулж байна. Энэ аргаар инфляцийг бууруулж болохгүй нь. Тэгэхээр өөр ямар арга зам байна вэ? Одоогийн авч хэрэгжүүлж байгаа бодлогыг хэрхэн ойлгох вэ? Одоо хэрэгжүүлж байгаа бодлогын нэг чухал зүйл нь инфляци өсөж байгаа нөхцөл байдалд санхүүгийн бодлогоо өөрчлөхгүй байх явдал юм. Харин тодорхой хэмжээгээр сулласан мөнгөний бодлогыг тогтвортой мөнгөний бодлогоор өөрчлөх хэрэгтэй. Яагаад урьдын адил мөнгөний бодлогыг чангатгахгүй вэ? Гол учир нь одооны инфляци бол 90-ээд оныхоос өөр. Тэр үед эрэлтийн инфляци үүсч байсан. Тиймээс санхүүгийн бодлого ч, мөнгөний бодлого ч хатуу чанга байсан. Гэтэл үр дүнд дифляци үүссэн. Одоо бол үнийн нэмэгдлийн шалтгаан голлож байна.

Бид одоо зөвхөн тогтвортой мөнгөний бодлого барихаас гадна мөнгөний урсгалын

хэмжээг буцаад хэвийн төвшинд аваачих хэрэгтэй. Түүнчлэн мөнгөний бодлогын бүтцэд зохицуулалт хийх хэрэгтэй. Учир нь мөнгөний бодлогод нийт дүнгийн зохицуулалт ба бүтцийн шинжтэй зохицуулалт хийдэг. Урьд нь манай улс мөнгөний бодлогод нийт дүнгийн зохицуулалт хийдэг байсан. Жишээ нь хадгаламжийн хүүгийн өсөлт бол нийт дүнгийн зохицуулалт. Ашгийн хэмжээ өссөнөөр нийт дүнг зохицуулна. Энэ нь нэг далайлтаар бүтцийг нэг тийш нь болгох муу талтай. Гэтэл Хятад бол жигд бус хөгжиж байгаа улс. Хятадын үнийн нэмэгдлийн инфляцид түүхий эд, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хомсдол байгаа нь харагдаж байна. Тиймээс нэг далайлтаар шийдэх арга хэрэглэж болохгүй. Жишээ нь бүтцийн зохицуулалт хийх аргаар шийдвэрлэх арга зам байна уу гэдгийн эрж хайх хэрэгтэй. Хэрвээ хүү 1%-иар өслөө гэхэд, зүүн нутгуудад 1%, төв нутагт 0,5%, баруун нутгуудад хэсэг зуурт хүүг өсгөхгүй байх эсвэл маш бага хэмжээгээр жишээ нь 0.2%-иар өсгөх зэргээр зүүн ба баруун бүсийн нутгуудыг ангилж үзэх хэрэгтэй. Хүүгийн хэмжээг нэмэхдээ ч, бүтцийг нэгэн адил төвшинд шийдэж болохгүй. Бараа бүтээгдэхүүний илүүдэлтэй газарт зээлийн хүүг нэмж, жигд тэнцвэртэй бараатай газрын зээлийн хүүг арай багаар тооцож, барааны хомсдолтой газарт жишээ нь өндөр технологийн салбарт зээлийн хүүг маш багаар тогтоох аль эсвэл огт хүүгүй болгох хэрэгтэй. Ингэж байж л нийлүүлэлтийг нэмэгдүүлж чадна.

Бас нэгэн арга зам бол, өнөөгийн үнийн нэмэгдлийн инфляцийн үед газрын үнэ, үл хөдлөхийн үнийн улсын зохицуулалтыг чангатгах хэрэгтэй. Энэ бол улсын төсөвт

шууд нөлөөлөхөөс гадна, ард түмний амьдрах орон сууцны үнэ хөлсөнд хамаарах асуудал бөгөөд инфляцийн шууд шалтгаан юм. Эрэлтийн инфляци байрны үнэ, газрын үнийг өсгөдөг. Даамжраад нийгмийн тулгамдсан асуудал болдог. Түрээсийн үнэ нэмэгдэж, байрны үнэ өсдөг. Цалингийн өртөг ч өсдөг. Эдгээр бүх асуудлыг бид сайн бодолцох ёстой. Ерөнхийдөө үнийн өсөлтийн инфляци бол шинэ хэлбэрийн инфляци. Энэ төрлийн инфляцийг бид нарийн нягталж, судлах хэрэгтэй байна.

3. Ажил эрхлэлт

Хятадын ажил эрхлэлт бол өөрийн гэсэн онцлогтой. 2008 оны 11 дүгээр сард би Баруун Европод уригдаж лекц уншсан. Тухайн үед олон улсын санхүү эдийн засгийн хямрал Хятадад нөлөөлөөд эхэлсэн үе. 2008 оны 11 сард Хятадын эдийн засгийн өсөлт 6 гаруй хувь болж буурсан. Баруун Европын эдийн засагчид тэгэхэд надаас асууж байсан, манай Баруун Европод бол жил бүр 2%-оос 3%-ийн өсөлттэй байдаг, бид ч сэтгэл хангалуун байдаг, ийм хэмжээний өсөлттэй байхад ажилгүйдэл үүсдэггүй. Танай Хятадад яагаад 9-10%-ийн өсөлттэй байх хэрэгтэй байдаг юм бэ? Одоо өсөлт 6%-тай болж буурсан байна. Бидний зүгээс харахад энэ бол хангалттай өндөр үзүүлэлт. Гэтэл танай улсад дээр дооргүй сандарцгаах юм. Ажилчид ажлын байргүй болж, нутаг буцацгааж байна, тэд нар ажилгүй болоод нутаг орон руугаа буцахгүй хотод үлдвэл яах вэ гэх зэрэг асуудлуудыг ярьцгааж байсан. Баруун Европынхон бол үүнийг ойлгохгүй. Танай Баруун Европын улс орнууд аж үйлдвэржээд 200 гаруй жил болсон. Танай хөдөөд илүүдэл ажиллах хүч гэж нэгэнт байхгүй болсон. Одоо Баруун

Европын хөдөөний оршин суугч нийт хүн амын хэдхэн хувийг эзэлдэг. Тэгээд ч танай хөдөөний хүмүүс бүгд эзэмших газартай, гэр бүлийн фермтэй, хөдөө тосгондоо өөрийн гэсэн орон сууцтай байдаг. Хөдөө хотын амьдралын төвшин бараг ижил. Нийгмийн халамж бүх давхаргыг хамарсан. Танай улсын хөдөөний хүмүүс одоо хотод очиж ажиллах шаардлага байхгүй. Тэдний өвөө эмээгийнх нь үед л хот руу явах шаардлагатай байсан. Гэтэл Хятадад нөхцөл байдал тэс ондоо. Хөдөөний хүмүүс тасралтгүй хотод орж ирж байна. Тэд нар ажиллаж мөнгө олохоос гадна хотын оршин суугчидтай адил төвшний нийгмийн байр суурьтай болох хэрэгтэй. Тиймээс бидний хувьд эдийн засгийн өндөр өсөлттэй байх зайлшгүй шаардлагатай. Энэ нь байгаль орчин бохирдуулах, нөөц баялаг хурдан дуусах, хотын амьдралын төвшин буурах гээд сөрөг талтайг хүн бүр мэдэж байгаа боловч эдийн засгийн өсөлт 6 хувь болж буурахад санаа зовохгүй байхын аргагүй юм.

Бидний хамгийн их санаа зовж байгаа зүйл бол инфляци биш стагфляци юм. Стагфляци гэдэг нь инфляци ажилгүйдэл хоёр зэрэг үүсэхийг хэлнэ. Барууны хөгжилтэй улсуудад эдийн засгийн өсөлт 1%-иас бага байхад стагфляци үүсдэг. Яагаад 1% гэж хязгаар тогтоож байна вэ гэхээр, хүн амын өсөлт дунджаар 1% орчим байдаг. Гэтэл Хятадын эдийн засгийн өсөлт 6% болж буурахад Хятадад ажилгүйдэл хичнээн их гарч байгааг харж байна уу. Жил бүр шинэ ажиллах хүчний ойролцоогоор 75%-ийг хувийн хэвшлийнхэн шингээдэг. Хувийн хэвшлийнхний гүйцэтгэх үүрэг асар их. Тиймээс ажилгүйдлийг арилгах хамгийн сайн арга бол хувийн хэвшилд хандуулах төрийн бодлогыг сулруулах юм.

Жишээ нь татвар багасгах. Санхүүгийн асуудлаа шийдэхэд нь тусламж дэмжлэг үзүүлэх, эрх тэгш хандах гэх зэрэг. Хятадад нийт улс даяар 30 сая хувийн аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. Тэд бизнесээ өргөжүүлж үйл ажиллагааны хүрээгээ тэлэх сонирхолтой байдаг. Тэд гэр бүл, хамаатан саднаасаа нэг хүнийг авч ажиллуулахад л хэдэн арван сая ажлын байр шинээр бий болох юм. Хятадад нийт 10 сая жижиг дунд үйлдвэр байна. Нэг нь 3 юмуу 5 хүн авч ажиллуулахад л хэдэн арван сая хүн ажлын байртай болно.

Хятадын Чунцин хотод саяхан шинэ бодлого хэрэгжүүлж эхэлсэн. Гадаадад аж ахуйн нэгжийг том, дунд, жижиг, бичил гэж 4 ангилдаг. Хятадад том, дунд, жижиг гэж 3 ангилдаг. 300-аас бага ажилтантай л бол жижиг бизнес гэдэг. Одоо Чунцинд хэрэгжүүлж байгаа бодлогоор юуны өмнө бичил бизнесийн тодорхойлолтыг тогтоосон. Нэгдүгээрт, ажилтны тоо нь хөрөнгө оруулагч өөрөө ороод 20 хүнээс хэтрэхгүй байх. Хоёрдугаарт, бизнес эхлүүлэх дүрмийн сан нь 100 мянган юань хүртэл байна гэж заан тогтоосон. Энэ хоёр шалгуурыг хангаж байгаа бол бичил бизнес гэж нэрлэнэ. Бичил бизнест ямар урамшуулал олгох вэ?

- 1) Татварын хөнгөлөлт үзүүлнэ
- 2) Банкнаас зээл авахад засгийн газраас батлан даалт гаргана
- 3) Ажилтныг дадлагажуулахад засгийн газраас зардлыг нь даана
- 4) Бизнес эхлүүлэхэд бүрдүүлэх шаардлагатай бичиг баримт бүрдүүлэх, банкинд данс нээх үе шатыг хялбарчлах

Энэхүү бодлогыг хэрэгжүүлснээр Чунцин даяар шинэ бизнес эхлүүлэх давалгаа үүссэн. Бичил бизнес эхлүүлэхэд хамгийн

тохиромжтой хүмүүс бол их сургууль төгсөгч, тэтгэвэрт гарсан ажилчин, хөдөөнөөс ирсэн ажилчин, цэргээс халагдсан хүн, тахир дутуу иргэн, нутаг шилжиж ирсэн хүмүүс юм. Энэ бол нэгэн шинэ гарц юм. Тиймээс Хятадын ажил эрхлэх асуудал бага багаар шийдэгдэх боломжтой болж байна.

4. Шинийг санаачлах

Эдийн засгийн өсөлт өнөөг хүртэл хөрөнгө оруулалтад дөрөөлсөн хэвээр байгаа билээ. Экспорт хэдий чухал боловч, экспортод тулгуурласан эдийн засагтай болж хэрхэвч болохгүй. Учир нь бид гадаадаас хамааралтай болж хувирна. Тэгээд ч үнэндээ одоогийн Хятадын экспортоос бидэнд өөрт оногдох ашиг маш бага байгаа. Ихэнхи ашиг нь гадаадын компанид орж байна. Шалтгаан нь бид барааны эрхийн тухай мэдлэггүй байна. Өөрийн гэсэн брэндгүй тул гадны брэндийн нэрээр бараа бүтээгдэхүүнээ гаргадаг. Бидний олж байгаа ашиг бол зөвхөн боловсруулалтын ашиг төдий. Ийм нөхцөл байдлыг өөрчлөх цаг нь болжээ. Яаж өөрчлөх үү? Юуны өмнө шинийг санаачлах хэрэгтэй. Брэнд бол шинийг санаачилсны үндсэн дээр бий болдог. Барааны эрхийг шинийг санаачлагч л эзэмшинэ.

Энд 2 сургамжтай жишээг дурьдая. Эхний сургамж бол, 20 дугаар зууны 90-ээд оны сүүлчээр бид өнгөт телевиз хийх салбарт дэлхийд тэргүүн эгнээнд явж байв. Гэтэл бидний шинийг санаачлах хурд бусдаас хоцорсон. 21-р зуун болоход шингэн дэлгэцтэй, плазма телевиз гээд шинэ бүтээгдэхүүнүүд маш хурдан гарч ирж хуучин телевизийг дорхноо шахаж гаргасан. Шингэн дэлгэц, плазма зурагтын үйлдвэрлэлээр Япон эхэнд явж байна. Бид одоо Японыг гүйцье гэхэд

нэлээд хугацаа шаардагдана. Хоёрдахь жишээ бол, бас л 20-р зууны 90-ээд оны сүүлээр манай зургийн аппарат бас дэлхийд эхний эгнээнд л байсан. Гэтэл бид бас л технологийн дэвшлээс хоцорсон. 21-р зуунд дижитал аппарат гарч уламжлалт зургийн аппаратыг орлосон. Япон дахиад л хошуучилж эхэлсэн. Энэ хоёр жишээ бидэнд шинийг санаачлах хурд чинь удаан байна гэдгийг харууллаа. Эцсийн эцэст бид л хохирлоо. Тиймээс шинийг санаачлахыг маш сайн дэмжих хэрэгтэй. Шинийг санаачилснаар манай аж ахуйн нэгж, бараа бүтээгдэхүүн олон улсын тавцанд өрсөлдөх чадвартай болно. Брэнд ч мөн адил шинийг санаачилснаар байр сууриа хадгалж чаддаг. Зарим хүн шинийг санаачлах гэдэг бол мэдлэг хуримтлагдаж байж бий болдог гэдэг. Технологи, үгүй ядаж хөрөнгө мөнгө тодорхой хэмжээгээр хуримтлагдсан компани л шинийг санаачилж чадна гэлцэнэ. Хятадад бол ажиллах хүч л хуримтлагдсан, яаж шинийг санаачилах юм бэ гэдэг.

Саяхан Гуандунд тусгайлан жижиг, дунд үйлдвэрийнхэнд зориулан уулзалт зохион байгуулав. Уулзалтын үеэр тэд, бидэнд ажиллах хүч байна түүний хажуугаар шинэ содон зүйл ч санаачилж байна гэсэн. Нэгдүгээрт, хувцасны загвар дизайныг шинэ санаагаар хийж байна. Адилхан л хувцас, арьсан гутал, тоглоом хийсэн ч гэсэн дизайн дээрээ шинэ зүйлүүд оруулж байна. Хоёрдугаарт, түүхий эд сонгохдоо шинэ санаа гаргаж байна. Гуравт, байгаль орчин хамгаалах тал дээр шинэ санаачилга гаргаж байна. Одоогийн бараа бүтээгдэхүүн нь өмнөхөө бодвол эрчим хүч бага хэрэглэдэг болжээ. Дөрөвт, түүхий эд болон эрчим хүч хэмнэх тал дээр шинэ санаа сэдсэн. Тавд,

борлуулалтын шинэ арга хэрэглэж байна. Зургаад, аж ахуйн менежментийг шинэчлэн, гэр бүлийн системээр удирдахаас татгалзан, орчин үеийн аж ахуйн нэгжийн бүтэцтэй болгох гэх зэргээр шинэ аргууд нэвтрүүлж байна. Эндээс харахад шинэ санаачлага гэдэг нь ямар ч хэлбэрээр байж болно. Гуандуны жижиг дунд бизнес эрхлэгчдийн хэлсэн зүйлсээс санаа авах зүйл их байлаа.

Дотоодын хэрэгцээгээ өсгөх яагаад чухал вэ? Бид сая хөрөнгө оруулалт голлосон эдийн засгийн өсөлт болон экспортод тулгуурласан эдийн засгийн өсөлтийг ярилаа. Аль аль нь удаан хугацаанд явах зам биш юм байна гэдгийг ойлголоо. Тэгвэл удаан хугацаанд дагах ямар арга байна вэ? Өөрсдийн дотоодын хүч бололцоонд тулгуурлах хэрэгтэй. Эдийн засгийн өнцгөөс нь харахад хөрөнгө оруулалтаар бий болсон хэрэгцээ бол дундын хэрэгцээ. Харин хэрэглээнээс үүсэх хэрэгцээ бол эцсийн хэрэгцээ юм. Тиймээс бид дотоод хэрэгцээгээ нэмэгдүүлснээр эдийн засгийн өсөлт бий болгох замыг л сонгох хэрэгтэй. Ингэж байж л эдийн засгийн зөв эргэлтийг бий болгоно. Тэгэхээр хэрхэн дотоодын хэрэгцээгээ нэмэгдүүлэх вэ гэдэг асуулт гарч ирж байна? Хоёр талаас нь задалж үзье. Нэгд: олонхи болох бага орлоготой хэрэглэгчдийг санаа зовох зүйлгүй болгох хэрэгтэй. Яагаад хүмүүс худалдан авалт хийхгүй байна вэ? Тэд худалдаж авахаас айж байна. Тэд арайхийж олсон мөнгөө дэмий үрээд яах вэ, дараа нь хүү маань хуримаа хийхэд байрыг нь яаж авах билээ гэж санаа зовон мөнгөө хадгалдаг. Хэдэн жилийн дараа хүүхэд их сургуульд орно, тэр үед хаанаас мөнгө олох вэ? Өвдөөд эмнэлэгт хэвтэх болбол яах вэ? Тэр бүхэнд мөнгө хураах хэрэгтэй. Хэрвээ ажилгүй

болбол яах билээ гэх зэргээр байнга санаа нь зовинож байдаг.

Энд та бүхэнд барууны эдийн засагчдын дунд өрнөсөн нэгэн маргааныг ярья. 1929 онд дэлхийг хамарсан их хямрал үүссэн. Тэр хямралыг 30-аад оны хямрал гэдэг. Ажилгүйдэл асар их газар авч, ажилгүйдэл хамгийн чухал асуудал болж байсан. Яаж ажилгүйдлийг бууруулах билээ? Тухайн үед эдийн засгийн онолын гол чиглэл Английн шинэ сонгодог онол байсан. Хоёр гол төлөөлөгчтэй байсан. Нэг нь Робинс, нөгөө нэг нь Канан. Энэ хоёр ажилгүйдлийг бууруулах арга дэвшүүлсэн. Тэдний онолоор бол 1 хүний ажлыг 2 хүн хийж, 1 хүний цалинг 2 хүн хувааж авахад л болно гэж үзэж байсан. Энэ үед Шведийн залуухан эдийн засагч Мирдал (тэрээр хожим нь эдийн засгийн салбарын Нобелийн шагнал авсан) болон түүний залуу хамт ажиллагсад Шведийн засгийн газарт санал бичиг хүргүүлсэн. Ажилгүйдлийг бууруулах хамгийн чухал арга зам бол эрүүл халамжийн тогтолцоо юм гэсэн. Засгийн газар хөрөнгө гаргаж хямд түрээстэй байр, нийтийн байр барьж ядуу хүмүүсийг оруулах хэрэгтэй. Үнэ төлбөргүй боловсрол, эмнэлгийн үйлчилгээ, ажилгүйдлийн даатгал, тэтгэврийн тогтолцоог бий болгох хэрэгтэй гэсэн. Шведийн засгийн газар тэдний саналын дагуу бодлого боловсруулж, ийнхүү халамжийн улс гэсэн ойлголт Шведээс эхлэн бий болсон юм.

1936 он болоход Кейнсийн эдийн засгийн онол үүсэн гарч ирэв. Кейнсийн гол ном болох "Ажил эрхлэлтийн ерөнхий онол" чухамхүү 1936 онд гарсан. Энэхүү номондоо тэрээр ажил эрхлэлтийн тухай бодлого боловсруулсан. Олон ч ажилгүйчүүдийг

байна вэ? гэж байсан. Тариачид үүнд их гомдолтой байсан. Газар нь нийтийн эзэмшлийнх учраас байрны эзэмших эрхийн гэрчилгээ өгөхгүй байна гэдэг бол нөгөө талаар байраа барьцаанд тавьж болохгүй, бусдад шилжүүлж болохгүй, тэр байтугай түрээслүүлж ч болохгүй байдалд хүргэж байна. Тэгэхээр нь бид түрээслэхэд ямар бэрхшээл гарч байна вэ? гэж асуусан, хариуд нь хэрвээ түрээсэлсэн хүн нь гарахгүй гээд суучихвал яах вэ? Шүүхдэлцэх хэрэг гарна. Хэдэн сар түрээсийн мөнгөө төлж байснаа төлөх аргагүй болоод хөөгөөд ч гарахгүй байх тохиолдлууд байдаг. Тиймээс бид аргагүйн эрхэнд ойр дотно хамаатан садандаа л маш хямд үнээр байраа түрээслэхээс өөр аргагүйд хүрдэг гэсэн.

Тэгвэл одоо Шанхай хотын жишээг харья. Шанхай хотын "Соёлын мэдээ" сонины 2010 оны 6 дугаар сарын 5-нд гарсан нийтлэлд бичсэнээр Шанхай хотын Жиадин дүүргийн шинэ оршин суух тосгоны тухай бичсэн. Шинэ тосгоны айл өрхийн байр нь 200 гаруй м², 3 өрөө. Нэг өрөө нь 110 м², нэг нь 80 м², үлдсэн нь 60 м², айлууд 2 өрөөнд нь амьдарч, нэг өрөөгөө түрээслэнэ. Ам бүл цөөтэй нь 110 м² өрөөгөө түрээслэх боломжтой. Бүгд байр эзэмших эрхийн гэрчилгээтэй бөгөөд 3 жилийн дараа байраа зарж ч болно.

Хятадын улс төр эдийн засгийн байнгын хорооны хурлын зохицуулалтын албаны баг Шандун мужийн Анхай хотод тариачдын орон сууцны талаар судалгаа хийсэн. Анхай хотын дүүргээс холгүйхэн хэдэн засаг захиргааны тосгон нийлэн нэг хороолол барьжээ. Биднийг очиход тариачид шинэ байрандаа нүүн орцгоож байсан. Айл бүрт тус бүр нь 100 м² орчим том байр олгосны нэгэнд нь амьдарч,

нөгөөг нь түрээслэж байсан. Хэрэв зөвхөн нэг байр хэрэгтэй гэвэл, нөгөө байрных нь үнийг бодоод бэлэн мөнгө олгох системтэй. Тариачид үүнд их баяртай байсан. Ихэнх нь нэг байраа түрээслэхээр авч байсан. Яагаад түрээслэх нь ашигтай вэ гэхээр мэдээж ингэснээр байнгын орлоготой болно. Хэнд түрээслэх вэ гэхээр, хотод ажилтай хүмүүст түрээслэнэ. Тэд нар хотод түрээсийн байр олж чадахгүй, байр худалдан авах чадваргүй учраас хотын ойролцоо тосгонд байр түрээслэх дуртай. Мотоциклоор ажилдаа явахад дороо хүрнэ. Оршин суух байранд нь машины зогсоолтой. Биднийг очиход хүмүүс байрандаа нүүн орж байсан. Хөшиг, хивс, тавилга, цахилгаан бараа худалдан авцгаагаад л, их хөгжилтэй байсан. "Бид хөрөнгөтэй, байнгын орлоготой боллоо" гэж баярлацгааж байлаа. Байрны түрээс авч байгаа нь дотоодын хэрэгцээг өсгөхөд сайн нөлөө үзүүлнэ.

19-р зууны дунд үед Франц улсад аж үйлдвэржилт хөгжсөн. Хөдөө тосгоныхон олноороо хот руу нүүх болсон. Гэхдээ Францад аж үйлдвэржилтийн үед нийгмийн замбараагүй байдал бий болоогүй. Яагаад Францад аж үйлдвэржилт, хотжих явцад эмх замбараагүй байдал үүсээгүй вэ? Үүнийг Францын түүхтэй холбож тайлбарлах хэрэгтэй. 1789 онд Францад хувьсгал гарсан. Газрын эзэд олноороо гадаадад дүрвэн гарсан. Якобчууд төрийн эрх барьж байх үед, нутгаасаа гарсан газрын эздийн эзэмшиж байсан газрыг хураан авч, газаргүй хүмүүст хуваан өгсөн. Ингэж Франц тариачид жижиг хэмжээний газар эзэмших эрхтэй болцгоосон. Наполеон гарч ирсний дараа хуулиар энэхүү газар эзэмших эрхийг нь баталгаажуулж өгсөн. Тариачдын газар эзэмших эрхийг баталгаажуулсан. 1815

онд Наполеон огцорч, оронд нь хаант эрх дахин тогтож, олон хуулийг дахин өөрчилсөн. Гэхдээ газрыг буцаан авч зүрхлээгүй. Учир нь олон сая хүн газар авсан байсан. Тэднээс газрыг буцааж авна гэдэг бүтэхгүй асуудал. Ингэж Франц улсын газар эзэмших тогтолцоо үүссэн. Францад аж үйлдвэржилтийн үед үл хөдлөх хөрөнгө дэнчинд авдаг банк үүссэн. Дэнчин бол барьцаанаас өөр. Барьцааны хамгийн тод жишээ бол ломбард. Бугуйвчаа тавиад мөнгө зээлэхдээ ломбарданд бугуйвчаа барьцаа болгон үлдээдэг. Хугацаанд нь зээлсэн мөнгөө өгөхгүй бол бугуйвчийг ломбардын газар авна. Дэнчин бол өөр, байр нь чинийх хэвээрээ, байрны ордероо дэнчинд тавихад л болно. Газар дээрээ чи ногоогоо тарьж болно, зөвхөн газар эзэмших гэрчилгээгээ өгнө. Хэрэв хугацаандаа мөнгөө төлөхгүй бол банк шүүхэд хандана, шүүх эцсийн шийдвэр гаргана. Тиймээс Францын ард иргэд газраа дэнчинд тавиад хот руу нүүж байсан. Газар эзэмших гэрчилгээ, байрны гэрчилгээгээ өгөөд л мөнгө авчихна. Байрандаа амьдрана, газраа ч ашиглангаа, мөнгөтэй болоод хот орно. Хотод очоод дэлгүүр нээнэ, жижиг худалдаа эрхэлнэ. Ажил хийсэн ч гэсэн байр түрээслэх эсвэл худалдан авах боломжтой болно. Дараа нь аажмаар зээлээ дуусгаж, хөдөө нэг байртай, хотод бас нэг байртай болно. Тиймээс Францын нийгэм хэвийн тогтвортой үргэлжилсэн.

Латин Америкийн орнуудад аж үйлдвэржилтийн үед хотод маш их замбараагүй байдал үүссэн. Хаа сайгүй ядуус. Латин Америкийн орнуудад тариачид газар эзэмших систем байгаагүй. Тариачид бүгд хөлсөөр ажилладаг байсан. Газаргүй, байргүй. Амьдрах байрыг нь газрын эзэн бэлдэж өгөх,

эсвэл өөрсдийнхөө барьсан сүрлэн оромжинд амьдардаг байсан. Тиймээс тэдгээр тариачдад дэнчинд тавих юм байхгүй. Хотод очоод л ядуусын эгнээг нэмэгдүүлнэ. Дагаад нийгэмд сөрөг нөлөө үзүүлж байсан.

5. Хот хөдөөгийн нэгдмэл байдал

Хот хөдөөгийн нэгдмэл бүтэц, хот хөдөөгийн заагдмал бүтэц гэж байна. Хот хөдөөгийн нэгдмэл бүтэц бол эрт үед ч байсан. харин хот хөдөөгийн заагдмал бүтэц бол 1958 оноос хойш бий болсон. Хятадад эрт үед хот хөдөөгийн нэгдмэл бүтэц байсан нь илэрхий байдаг. Харин заагдмал систем байгаагүй. Алтан улсын цэрэг Хойд Сүн улсын нийслэлд эзлэн орсноор Хойд Сүн улс мөхсөн. Сүн Вэйзун, Сүн Руанзун эцэг хүү хоёрыг Хар мөрөн мужид цөлсөн. Сүн Гаозун Өмнөд Сүнийг байгуулж, Хөнань, Шаньдун, Хөбэйгийн хүмүүс Жяннань руу дүрвэсэн. Тухайн үед хот хөдөөгийн нэгдмэл бүтэц байв. Тиймээс Жяннаньд очсоны дараа тариачдын хотод амьдрахыг хүссэн нь хотод амьдарч, байр байшин худалдан авч, дэлгүүрт ажиллах, дэлгүүр нээн ажиллуулах, өөрөө амьдрах байраа барих зэргээр хотод үлдэцгээж байв. Харин хотын хүмүүс Жяннаньд очоод хөдөө тосгонд газар авах, газар түрээслэх, тариа тарих, байшин барих боломж ч бүрдсэн. Ямар ч гэсэн хотын хүн хөдөө амьдрах, хөдөөний хүн хотод амьдрах боломжтой болсон юм.

Саяхан "Туандунг эзэлсэн нь" гэдэг олон ангит кино гарсан. Кинонд Чин гүрний сүүлч, Мин гүрний эхэн үеийн тухай гардаг. Шаньдун мужийн хүмүүс Зүүн хойд нутаг руу нүүн очоод хотод амьдрах хүсэлтэй нь хотод, хөдөө амьдрах хүсэлтэй нь хөдөө амьдарна. Хот хөдөөгийн заагдмал систем хэзээнээс бий болсон бэ? 1958 онд суурьшлыг

хоёр ангилсан байна. Хотын суурин иргэд, хөдөөгийн суурин иргэд гэж хоёр хуваасан. Ингэж хот хөдөөг зааглаж, хот хөдөөгийн нэгдмэл бүтцийг салгаж системчилсэн байна. Түүнээс хойш хөдөөгийн тариачид өөрийн эрхгүй хоёрдугаар зэрэглэлийн иргэн гэгдэх болжээ. Жишээ татъя:

Эхний жишээ. Төлөвлөгөөт эдийн засгийн үед хотын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг засгийн газар хянадаг байсан. Хотын иргэдийн ажлыг ч засгийн газар хариуцна. Яаж хариуцах вэ гэхээр, чи хэрвээ ажил хиймээр байгаа бол, гудамж цэвэрлэх эсвэл мод тариад нэг сард 20, 30 юаний цалин авч болно. Бараа хомсдол, хүнсний, шатахууны, мах, өндөгний талон олгоно. Гэтэл хөдөө бол өөр. Бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг төр засгаас хянана. Гэхдээ амьжиргааг төр засаг хариуцахгүй. Тиймээс хүнд хэцүү үед улс даяар 20 сая гаруй хүн өлсөж үхсэн нь бүгд тариачид байсан. Хотын хүмүүс чанаргүй хүнс хэрэглэж, хавантаж, өвдөж үхэж байсан боловч өлсөж үхээгүй юм.

Хоёрдахь жишээ. Олон жилийн турш хотын хүүхдүүд ерөнхий боловсрол эзэмшихдээ сурах сургуулийг нь засгийн газраас хөрөнгө гаргаж бариулж ирсэн. Багш нарын цалинг ч төсвөөс гаргана. Харин хөдөө бол сургуулийг тариачид өөрсдөө барина. Багш нар нь орон тооны биш орлогч багш нар. Цалинг нь тариачид өөрсдөө гаргана. Адилхан л ерөнхий боловсрол боловч хот хөдөөд олон жилийн турш харилцан адилгүй явсаар ирсэн. Энэ байдлыг одоо л засч залруулж эхэлж байна.

Гуравдахь жишээ. Өөрчлөлт шинэчлэл эхэлснээс хойш, хот хөдөөгийн заагдмал бүтэц арай суларсан. Тариачид хотод ажиллах боломжтой болсон. 80-аад онд хотод ирсэн

тариачид өөрийн харьяа газраасаа хотод ажиллах зөвшөөрөлтэй ирдэг байсан. Хэрвээ ийм зөвшөөрөлгүй нь мэдэгдвэл нутаг буцаана. Тухайн үеийн бодлого нь ийм байсан. Харин хотын хүн хөдөө очиж байр түрээслэх, биеэ сувилах, зураг зурах, бичих гээд хэдий удаан хугацаагаар хөдөө байсан ч хэн ч тоохгүй. Хэзээ ч хөдөөнийхөн хотын хүнийг нутаг буцааж байсангүй. Оршин суух зөвшөөрлийг нь шалгана гэсэн асуудал гарахгүй. Энэ бас л нэг эрх тэгш бус байдал юм.

Дөрөвдахь жишээ. Дэлхийн хаана ч "тариачин ажилчин" гэсэн ойлголт байдаггүй. Английн аж үйлдвэржилтийн үед ажилчид нь хаанаас ирдэг байсан бэ? Зарим нь хотын гар урчууд, зарим нь ойр орчмын хөдөөнөөс ирсэн тариачид. Хөдөөнөөс ирсэн тариачид хотод ирээд ажилчин болно. Хятадын хамгийн анхны үйлдвэрүүд Шанхай, Тяньжин, Гуандун хотуудад байгуулагдсан. Шанхайн ажилчид хаанаас ирдэг байв? Сунань, Субэйн хөдөө нутгаас. Тэд нар Шанхайд очиж ажил хийвэл, Шанхайн хүн болдог байсан. Эхнэр хүүхдээ Шанхайд аваачна, шинэ төрсөн хүүхэд нь Шанхайн иргэн болно. Тэгээд яагаад "тариачин ажилчин" гэдэг нэр гараад ирэв? Тариачин гэдэг нь хаанаас ирснийг нь, ажилчин гэдэг нь ажил мэргэжлийг нь хэлээд байгаа юм. Тиймээс 30 жил ажил хийсэн ч гэсэн "тариачин ажилчин" хэвээрээ л байна. Энэ бол яах аргагүй хот хөдөөгийн заагдмал бүтцээс үүсэн гарч байгаа юм. Одоо хүмүүс "тариачин бизнес эрхлэгч" гэж их ярьцгааж байна. Энэ үг ч гэсэн их сонин. Бизнес эрхэлж байгаа л бол бизнес эрхлэгч шүү дэ. Заавал урд нь тариачин гэж тодотгох хэрэг байна уу. Энэ нь хөдөөний бизнес эрхлэгч энэ нь хотынх гэж заавал ялгах хэрэгтэй гэж үү.

Төлөвлөгөөт эдийн засаг хоёр том хөшүүрэгтэй. Нэг нь төрийн өмчит аж ахуйн нэгжийн бүтэц. Энэ бүтцийн засаглал, хөрөнгө нь тодорхойгүй байдаг. Хоёрдахь нь хот хөдөөгийн заагдмал бүтэц. Хөдөөгийн тариачдыг хаашаа ч гарах гарцгүй болгосон энэхүү бүтцийн дунд тариачид хэзээ ч зохион байгуулалт, төлөвлөгөөтэйгээр гадагшаа гарч ажиллаагүй. Тэднийг "дураараа сэлгүүцэгсэд" гэнэ. Энэ нь юу гэсэн үг вэ гэхээр, төлөвлөгөөний дагуу биш дураараа загнаж байгаа учир "дураараа сэлгүүцэгсэд" гэж байгаа юм. Өөрчлөлт шинэчлэл эхлээд 30 жил өнгөрлөө. Эхний бүтцийг л голчлон өөрчилжээ. Төрийн өмчит аж ахуйн нэгжийн бүтцийг өөрчлөөд, харин хот хөдөөгийн зааг ялгааг одоо болтол олигтой шинэчлээгүй байна. Одоо л дөнгөж зарим нэг алхмыг хийж эхэлж байна. Хэдийгээр гүйцэтгэгчээр ажиллах систем бол хөдөөгийн шинэчлэлийн эхлэл гэж байгаа ч энэ нь нөгөө талаараа хот хөдөөгийн заагдмал бүтцэнд үндэслэн хийгдэж байгаа ажил юм. Зөвхөн хот хөдөөгийн заагдмал байдлын хурц хэлбэрийг л зөөлрүүлэх үйлдэл болоод байна. "тариачин ажилчин" бол "тариачин ажилчин" хэвээрээ, бусдад гадуурхагдсаар л байна.

Хот хөдөөгийн заагдмал бүтцийн өөрчлөлтөд хамгийн чухал асуудал аль нь вэ? Хамгийн гол нь харьяалалын асуудал биш. Хамгийн гол нь газрын асуудал юм. Харьяалал бол эцэстээ шийдэгдэх л асуудал. Аяндаа бүтнэ. Гэтэл газрын асуудал маш хэцүү. Яаж шийдэх вэ? Газрыг хоёр ангилах хэрэгтэй. Нэг нь түр ашиглах, нөгөө нь эзэмшил шилжүүлэх арга. Одоо олон газарт энэ хоёр аргыг нэвтрүүлж туршиж байна. Түр ашиглах нь газрыг түргэн эргэлтэд оруулна.

Түр ашиглалтын эрх шилжүүлэх, түрээслэх, хувь эзэмших гэсэн 3 аргаар газрыг түр ашиглаж эргэлтэд оруулж болно.

Газар эзэмшлийн солилцоо 2 үе шаттай байна. Эхний үе шат бол тариачин хот руу шилжихэд газрыг нь засаг захиргаа авна. Тариачин газар болон газар дээрхи байраараа хотын харьяаллыг хотод амьдрах байр, даатгалын хамт сольж авна. Зарим газарт ялангуяа настай хүмүүс сууж дадсан газраасаа холдож нүүх дургүй байх нь бий. Тэд нар нутагтаа гахай, тахиа тэжээгээд амьдрах дуртай. Хотод бол хаанаа гахай тахиагаа тэжээх вэ? Аав ээж нь хүүхдээрээ өвөө эмээг нь ятгуулж л хот руу шилжүүлж байна. Хотод ирээд сайн сургууль, цэцэрлэгт сурна. Өвдлөө гэхэд эмнэлэгт үзүүлэхэд хялбар болно гэх мэтээр хүүхдүүд настайчуудаа ятгана.

Хоёрдахь шилжүүлэх арга бол одоогийн бодлогоор тариачдын засаг захиргаанд тушаасан газар бол голдуу тэдний амьдарч байсан газар. Засаг захиргаа газрыг нь аваад дээр нь байсан байрыг нурааж тариалангийн газар болгож байгаа. Амьдарч байсан газар нь харьцангуй эрүүл сайн газар байдаг. Тэдний байр байсан газар бол угаасаа тариан талбай дундаасаа хэсэг газрыг нь үлдээж байр сууц барьсан газар учраас тариалангийн талбай нь томроод ирж байгаа юм. Дээр нь эргэн тойрны тариалангийн газар ч гэсэн гэр аж ахуйн талбай байсан учраас газрын өгөөж нь сайн эрүүл хөрстэй байдаг. Эдгээр газрын тухайн нутгийн засаг захиргаа нь нэгтгэн үйлдвэр барих боломжтой хэсгийг нь сонгож үйлдвэрийн дүүрэг барина. Энэ бол хоёрдахь шатны газар эзэмших солилцоо юм. Ингэснээр шинэ аж үйлдвэрийн дүүргүүд бий болно. Одоогийн байдлаар Чунцин, Чэндү хотод энэ

аргыг туршиж байна.

Бүх л хөгжингүй улс орнуудад хот хөдөөгийн нэгдмэл бүтэц хоёр чиглэлтэй байдаг. Харин одоо Хятадад нэг чиглэлээр явж байна. Энэ юу гэсэн үг вэ гэхээр, зөвхөн хөдөөнөөс хот руу шилжих хөдөлгөөн явж байна. Гэхдээ одооноос бага багаар өөрчлөгдөж байна. Жөзянь мужид энэ аргыг туршиж эхэлсэн. Хотын иргэн хөрөнгөө аваад хөдөө рүү шилжиж болно, хөдөөний иргэн ч гэсэн хөрөнгөө аваад хот руу нүүж амьдарч болж байгаа. Хотод байх хүсэлтэй нь хотдоо, хөдөөнөө байх дуртай нь хөдөөнөө амьдарна. Энэ нөхцөл байдлаас харахад, ирээдүйд Хятадад хэн тариа тарих вэ? Хөдөө амьдрах хүсэлтэй нь хөдөөнөө газар тариалан эрхэлнэ. Хөдөө амьдрах хүсэлтэй хүн мэдээж байдаг. Тэдний хүслийг харгалзах хэрэгтэй. Гэхдээ ирээдүйд газар тариалан эрхлэх хүмүүс 3 янз байна. Эхнийх нь газар тариалан эрхлэх туршлагатай хүмүүс байна. Тэд нар газраа түрээслэх, эрх шилжүүлэх аргаар зайнаас удирдаж ажил хэргээ явуулна. Үр ашиг нь ч их байна. Хоёр дахь нь мэргэжлийн хамтарсан компани хувь нийлүүлэх маягаар хамтран эрхэлнэ. Гуравдахь нь тусгайлан үрийн сорт сайжруулах гэх мэт нарийн мэргэжилтэн нар хамтарч газар тариалан эрхэлнэ. Тэд хөдөө хөдөө аж ахуйн компани байгуулна. Саяхан нэг жишээ гарсан. Зарим компани будаа тариалаад түүнийгээ далайн усаар усан туршиж байгаа гэнэ. Ингэснээр усалгааны асуудлыг шийдчихнэ. Зарим компани бас цөлд бордоо хэрэглэн ногоо тарихыг туршиж байна.

6. Хятадын эдийн засгийн хөгжлийн хөдөлгөгч хүч

Эдийн засгийн хөдөлгөгч хүч эцсийн эцэст ард түмний идэвхи зүтгэл юм. Засгийн газраас ард иргэдийн идэвх санаачлагыг дэмжиж, зөв

хөдөлгөх хэрэгтэй. Хэдэн жишээ дурьдая. Хятад улсын өөрчлөлт шинэчлэл хоршооллын систем нэвтэрснээр эхэлсэн. Тухайн үед энэ нь маш том эрсдэл дагуулсан ажил байлаа. Хятад улс картын барааны системтэй байсан 1979 онд Анхуй мужид анх ард иргэд хоршооллын системийг хэрэгжүүлж эхэлсэн юм. Анхуй мужийн жижиг тосгонд 18 өрх айл нийлж хэлэлцээ хийж, гарын үсэг зурж баталгаажуулсан байгаа юм. Тухайн үед энэхүү хэлэлцээг амь насаараа дэнчин тавьж хийсэн. Хэлэлцээний нэг заалт нь хэрвээ хэн нэг нь баригдвал, баригдсан нэгнийхээ үр хүүхдийг бусад нь санаа тавьж өсгөнө гэсэн заалт. Энэ бол ХКН-ын 11 дүгээр их хурлын дараа болсон үйл явдал. Төвөөс энэ системийг дэмжсэн. Тэгээд улс даяар өргөнөөр нэвтрүүлсэн. Хэдхэн жилийн дараа хоршооллын систем улс орныг хамарсан. Хэдэн жилийн дараа тариаланчдын худалдааны зах дээр тахиа, галуу, загас, тос, самар гээд байхгүй юмгүй болсон. Дахиад хэдэн жил өнгөрөхөд хүнс, шатахууны талон байхгүй болсон. Энэ бол бодит байдал. Гол нь нуугдаж байсан боломж бололцоо, идэвх зүтгэлийг зөв чиглүүлж чадсан юм.

Хоршооллын систем нэвтэрснээр тариачдын хөдөлмөр үнэлгээтэй болж тэд мөнгөтэй болов. Мөнгөтэй болсон тариачид үйлдвэрт очиж танилцан, үйлдвэрлэлийг хөдөө нэвтрүүлсэн. Тэд үйлдвэрээс тэтгэвэртээ гарсан туршлагатай хүмүүсийг өөрийн үйлдвэртээ урьж ажиллуулсан. Тухайн үед галт тэргэнд костюм өмссөн тариачид бизнесээ тэлэхээр ийш тийшээ явж эхэлсэн нь содон харагддаг байлаа. Тэд бараагаа хүмүүст сурталчилан зарж борлуулдаг байв. Нэгдсэн төлөвлөгөөт системтэй байхад хөдөө нутагт барааны захууд ажиллаж эхэлсэн. Ингэж анх төлөвлөгөөт

системд шинэ уур амьсгал орсон.

Бас нэгэн жишээ дурьдая. Хувьцааны систем хамгийн анх яаж үүссэн бэ? Хамгийн анх чухамхүү хөдөө нутагт л хувьцааны систем нэвтэрсэн. Тэд хувьцаа эзэмших системээр өөрсдийн аж ахуйгаа байгуулна. Ийм төрлийн аж ахуйнууд хаа сайгүй бий болсон. Гадаа гудамж талбайд хувьцаа зарж борлуулдаг байсан. Энэ нь явсаар бирж болон хөгжиж, хувьцааны тухай хууль гарсан юм.

Бас нэг жишээ бол ойг хамтран ашиглах бодлого. 1979 онд газар тариалангийн хоршооллын систем гарсан. Газрыг айл өрхүүдэд хуваарилан олгосон. Зарим газарт ой модыг ч гэсэн хуваарилан олгосон. Тэгснээр ой модыг маш ихээр устгасан. Учир нь урьд өмнө засгийн газрын шийдвэр бодлого хурдан өөрчлөгддөг гэж тариачид үзэн дахин шинэ шийдвэр гарахаас өмнө модыг нь зарж хурдхан ашиг олохоо бодож ойг зүй бусаар огтлон устгажээ. Хэдэн жилийн дараа дахиад газраа хураавал юу ч үгүй үлдэнэ гэж айцгааж хамаг модоо устгасан юм. Тухайн үед төв засгийн газраас ой мод устгахыг хориглосон ч маш их ой мод нэгэнт сүйдсэн байсан. 20 жилийн дараа, 21-р зуун гарахад сая ой модыг хамтаар эзэмших эрхийг өөрчилсөн. 2008 оны 6-р сарын 8-нд Төрийн Зөвлөлөөс шийдвэр гаргасан. Энэ бол бүхэл бүтэн 20 жилээр хоцорсон шийдвэр. Улс даяар 1.8 тэрбум му /1 му нь 0.667 га газартай тэнцэнэ. Орч/ тариалангийн талбай, 2.5 тэрбум му ой модыг тариачдад хуваан олгосон. Зарим өрхөд хэдэн зуун му уул оногдсон. Гол нь ашиглах эрхийг нь 70 жилээр тогтоосон. Ой модыг барьцаанд тавьж болно. Энэ бол бүгд шинэ гарсан бодлого. Ингэснээр ард иргэдийн идэвхи сэргэсэн. Одоо ой модтой

газарт очоод харахад тариачид маш ихээр мод тарьж байгааг харж болно. 70 жил ашиглах эрхтэй учраас өвөөгийнхөө тарьсан модыг ач нь тайрч болно гэсэн үг. Одоо бол хаа сайгүй л мод тарьцгааж байна. Хунань мужид нэгэн төрлийн цайны мод тариалдаг болсон. Тэрхүү модноос гарган авдаг тос нь чидун жимсний /олив/ тосноос ч сайн чанартай тос гэнэ. Одоо бол мод тарьснаар 1 чулуугаар 3 туулай онож байна. Мод тарьснаар тариачид жил бүр маш сайн орлого олж, зах зээл дээрхи тосны эрэлтийг хангаж, нөгөөтэйгүүр байгаль орчинд ч сайн нөлөө үзүүлж байна. Түүнээс гадна ойдоо тахиа шувуу үржүүлж, мөөг, эмийн ургамал тарьж, нэхмэлийн аж ахуй ч байгуулж байна.

Одоо Гуандунд ажилчид хүрэлцэхгүй байгаа гэнэ. Өмнө нь Гуандун руу Жяньси, Хунань мужуудаас тариачид олноороо очиж ажилладаг байсан. Одоо бол бүгд ой эзэмшиж, өөрөө ашиг олж аж ахуй байгуулж байна. Тэд нар заавал хотод очиж ажиллах шаардлагагүй болжээ. Энэ бол хөдөө нутагт гарсан шинэ өөрчлөлт юм. Энэ янзаар бол ой хамтран эзэмших систем нь Хятадын эдийн засгийн нэгэн шинэ хөшүүрэг болох боломжтой юм.

Та бүхэн эндээс Хятадын эдийн засгийн хөдөлгөгч хүч ард иргэдийн идэвхи санаачлагаас гардаг юм байна гэдгийг харж байна.

Хятад хэлээс орчуулсан С.Түмэнжаргал